



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/66

Сүхбаатар сум

Г  
Аймгийн Засаг даргын 2020 оны А/16, А/57  
тоот захирамжид нэмэлт өөрчлөлт оруулах, бэлэн  
байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.3, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.БНХАУ-д гарсан шинэ коронавирусийн халдвар (COVID-19)-ын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаагаар сунгасугай.

2.Монголын уламжлалт XVII жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярыг зөвхөн гэр бүлийн хүрээнд тэмдэглэхийг нийт ард иргэдэд уриалсугай.

3.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 64 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /Ч.Жаргалсайхан/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/ нарт даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан "Иргэдийн эрүүл мэндийн хамгааллыг сайжруулах, зарим үйл ажиллагааг түр хязгаарлах тухай" аймгийн Засаг даргын 2020 оны А/16 дугаар захирамжийн 1 дэх заалт, "Иргэдийн эрүүл мэндийн хамгааллыг сайжруулах, зарим үйл ажиллагааг түр хязгаарлах тухай" А/16 дугаар захирамжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай А/57 дугаар захирамжийн 1.1 дэх дэд

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430801196

заалтын “3 дугаар сарын 2-ны” өдөр хүртэлх гэсэн хугацааг “3 дугаар сарын 30-ны” өдөр хүртэл гэж өөрчилсүгэй.

5.“Иргэдийн эрүүл мэндийн хамгааллыг сайжруулах, зарим үйл ажиллагааг түр хязгаарлах тухай” А/16 дугаар захирамжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай А/57 дугаар захирамжийн 1.1 дэх дэд заалтын 1.3 дах хэсгээс “ ... фитнес” гэсэн заалтыг хасаж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургуулийн заалнаас бусад спорт заалны үйл ажиллагааг зөвшөөрсүгэй.

6.Энэхүү захирамжийг иргэд, олон нийтэд мэдээлэх, холбогдох байгууллагуудад хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

7.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан тус хугацаанд сумдын Засаг дарга, байгууллагын дарга нарыг хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад үед гадаад, дотоодын томилолтыг хязгаарлаж ажлын цагаар ажлын байрандаа байж, ажил үүргээ хариуцлагатайгаар гүйцэтгэж ажиллахыг сумдын Засаг дарга, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ